Дасан зохицох чадвар оюутны сурлагын амжилт, мэргэжил сонголтын сэдэл хоорондын хамаарлыг судалсан үр дүн

П.Батчулуун[1], С.Пагмадулам[1,2], Б.Энхбаяр[3], М.Туул[4]

[1]Этүгэн их сургууль, Эрүүл мэндийн сургууль
[2]АШУҮИС, Эрдмийн сургууль
[3]ОТИС, Хүмүүнлэгийн сургууль
[4]Шинжлэх ухааны "Авиценна" төв
Цахим шуудан: Batchuluun.p@etugen.edu.mn, Утас:89041919

Түлхүүр үг:
Сургалтын орчин
Дасан зохицох
Суралцах үйл

Товч утга:
Үндэслэл: Их сургуульд суралцах явц нь хувь хүний амьдралын хамгийн дарамт ихтэй, сэтгэл зүйн стресст өртөх эрсдэл бүхий үеийн нэг гэдэг нь судалгаагаар батлагдсан байдаг. Оюутнууд энэ үедээ дэмжлэг туслалцаа бага авахын зэрэгцээ үүрэг хариуцлага болон ачаалал ихэсдэг. Ажил эрхэлдэг хүмүүсийг бодвол их сургуулийн оюутнууд өөрсдөд нь тохироогүй илүү их ачаалалд ордог. Оюутны дасан зохицох чадвар нь сурлагын амжилтад эергээр нөлөөлж, хамааралтай байна гэсэн статистик үнэн бодит үр дүн гараагүй байна. Харин мэргэжил сонголтын хувийн ач холбогдол бүхий дотоод сэдэл нь сурлагын амжилт, дасан зохицох чадвар хоёрт нөлөөлж байгаа нь харагдаж байна. **Зорилго:** Оюутнуудын дасан зохицох чадвар сурлагын амжилтад нөлөөлж байгааг судлах
Арга, аргачлал: Судалгааг 2023 оны 3 сарын 30-ны өдрөөс 4 дүгээр сарын 05-ны хооронд нэг агшингийн судалгааны загвараар 189 оюутнаас таниулсан зөвшөөрлийн хуудсаар зөвшөөрөл авч, 72 асуулгаар 40 минутын хугацаанд судалгааг авсан. **Үр дүн:** Судалгаанд Этүгэн их сургуулийн их эмчийн мэргэжлээр суралцаж буй 2 дугаар дамжааны 189 оюутан оролцсон бөгөөд эрэгтэй 30 (15.9%), эмэгтэй 159 (84.9%) оюутан байна. Судалгаанд оролцогчдын 71% буюу 134 оюутан хөдөө орон нутгийнх, 29% буюу 55 оюутан Улаанбаатар хотод оршин суудаг байна. Судалгаанд оролцсон нийт оюутнуудын 33.9% хувь буюу 63 оюутан сургалтын үйл ажиллагаанд дасан зохицох чадвар сайтай, 65.9% буюу 124 оюутан сургалтын үйл ажиллагаанд дасан зохицох чадвар дунд зэрэг, 1.1% буюу 2 оюутан сургалтын үйл ажиллагаанд дасан зохицох чадвар муутай гэсэн үр дүн гарсан байна. **Дүгнэлт:** Судалгаанд хамрагдсан нийт оюутнуудын нийгэм, хамт олон сургуулийн орчинд дасан зохицох чадвартай оюутан судалгаанд оролцсон нийт оюутнуудын дийлэнх хувийг эзэлж байна. Оюутнууд нийгэм, сургуулийн орчин, анги хамт олондоо дасан зохицох чадвар сайн байх нь хичээлдээ явах идэвх санаачлага нэмэгдэж өөрийн сонгосон мэргэжлээ сайн эзэмшихэд нөлөөлж байна. Судалгаанд нийт хамрагдсан оюутнуудын 98,9% нь сургалтын үйл ажиллагаанд дасан зохицох чадвар сайн, дунд зэрэг гэсэн үр дүн гарсан байгаагаас харахад нийгэм, хамт олон, сургуулийн орчинд дасан зохицож чадсан оюутнууд, сургалтын үйл ажиллагаандаа дасан зохицоход хялбар болж байна. Нийгэм хамт олон сургуулийн орчинд дасан зохицох чадвар, сургалтын орчинд дасан зохицох чадвар хоорондоо хамааралтай байна.

Үндэслэл: Америкийн Нэгдсэн Улсад их, дээд сургуульд элсэн суралцагсдын 40% нь сургуулиа төгсөөгүй, түүнээс 57% нь хоёр дахь жилдээ элсэн суралцдаг гэсэн тоо баримт байна[1]. Элиас.Х нарын хамтарсан судалгааны бүтээлд "Сургууль завсардсан буюу төгсөхөөсөө өмнө сургуулиа орхисон хүмүүсийн 57% нь их сургуульд орсноос хойш амьдралдаа сэтгэл хангалуун бус байдаг гэжээ.[2] Мэргэжил сонголт

бол амьдралын бүхий л салбарт нөлөөлдөг нарийн төвөгтэй, олон талт үйл явц бөгөөд мэргэжлээ сонгох нь хувь хүний гаргадаг хамгийн чухал шийдвэрүүдийн нэг юм. Их, дээд сургуульд элсэж буй оюутнууд өөрсдийн сонирхол, авьяас чадвараас үл хамааран тодорхой чиглэлийг сонгож болно гэж дурьдсан байна.[3-5] Гэвч сонгосон мэргэжлээр ажиллах хүсэл эрмэлзэл нь дотоод сэдлээс үүдэлтэй байдаг[6].

Сургалтын үйл ажиллагаанд дасан зохицохын өндөр үзүүлэлт нь хичээлийн агуулгыг хөнгөн хүлээж авч, даалгаврыг цаг тухайд гүйцэтгэж чаддаг, шаардлагатай үед багшид хандан тусламж авч чаддаг, санаа бодлоо чөлөөтэй илэрхийлж, хичээл дээр хувийн онцлогоо илэрхийлж чаддаг оюутнуудыг тодорхойлно гэжээ.

Сургууль, хамт олны орчинд дасан зохицох түвшин өндөр байгаа нь оюутан бүлэгтээ тухтай байгаагаа мэдэрч, нийтлэг хэлийг амархан олж, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ дүрмийг төвөггүй биелүүлж дасан зохицдогийг илэрхийлнэ. Шаардлагатай үед бусдаас дэмжлэг авч чаддаггүй, нөхөд нь ч түүний үзэл, сонирхлыг хүлээн зөвшөөрдөггүй бол бага түвшинд байгааг тодорхойлно. Тэд ангийнхан, хамт суралцаж буй оюутнуудын хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, дүрэм, үзэл бодлын талаар ойлгох, хүлээн авах, боломж бага бөгөөд тэдэнд тусламж, дэмжлэг хэрэгтэйг илтгэнэ гэж тэмдэглэсэн байна. Иймээс бид оюутнуудын дасан зохицох чадвар нь сурлагын амжилтад хэрхэн нөлөөлж буйг шинжлэх ухааны үндэстэй судалгаа, шинжилгээний ажил явуулах хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.

Зорилго: Оюутнуудын дасан зохицох чадвар сурлагын амжилтад нөлөөлж байгааг судлах

Зорилт:

1. Оюутнуудын сургуулийн орчинд дасан зохицох чадварыг үнэлэх
2. Оюутнуудын сургалтын үйл ажиллагаанд дасан зохицох чадварыг үнэлэх
3. Оюутнуудын дасан зохицох чадвар сурлагын амжилт, мэргэжил сонгох сэдэл хоорондын хамаарлыг тодорхойлох

Арга, аргачлал: Судалгааг 2023 оны 3 сарын 30-ны өдрөөс 4 дүгээр сарын 05-ны хооронд нэг агшингийн судалгааны загвараар 189 оюутнаас таниулсан зөвшөөрлийн хуудсаар зөвшөөрөл авч, 72 асуулгаар 40 минутын хугацаанд судалгааг авсан. Бид судалгаандаа их сургуулийн оюутнуудын сургуулийн орчин, сургалтын үйл ажиллагаанд дасан зохицох чадварыг судлах Т.Д.Дубовицкая, А.В.Крылова нарын арга зүйг ашиглаж[9], хамт олны орчинд дасан зохицох, сургалтын үйл ажиллагаанд дасан зохицох гэсэн хоёр чиглэлээр оюутны дасан зохицлыг, мэргэжил сонголтын сэдлийг судлах Р.В.Овчаровагийн арга зүйгээр хувийн ач холбогдол бүхий дотоод сэдэл, нийгмийн ач холбогдол бүхий дотоод сэдэл, гадаад эерэг сэдэл, гадаад сөрөг сэдэл гэсэн 4 чиглэлээр оюутны мэргэжил сонголтын сэдлийг илрүүлсэн[10]. Т.И. Ильиний оюутны сурах сэдлийн илрүүлэх арга зүйгээр мэргэжил сонголтын сэдэл, диплом авах сэдэл, мэдлэг эзэмших сэдлүүдийг судлав[11].

Судалгааны бичиглэлийг MicroSoft Office 2019, үр дүнгийн статистик боловсруулалтыг STATA 15, номзүй, эшлэлийг AMA стандартаар бичиж гүйцэтгэв.

Үр дүн: Судалгаанд Этүгэн их сургуулийн их эмчийн мэргэжлээр суралцаж буй 2 дугаар дамжааны 189 оюутан оролцсон бөгөөд эрэгтэй 30 (15.9%), эмэгтэй 159 (84.9%) оюутан байна. Судалгаанд оролцогчдын 71% буюу 134 оюутан хөдөө орон нутгийнх, 29% буюу 55 оюутан Улаанбаатар хотод оршин суудаг байна.

Судалгаанд оролцсон нийт оюутнуудын 33.9% хувь буюу 63 оюутан сургалтын үйл ажиллагаанд дасан зохицох чадвар сайтай, 65.9% буюу 124 оюутан сургалтын үйл ажиллагаанд дасан зохицох чадвар дунд зэрэг, 1.1% буюу 2 оюутан сургалтын үйл ажиллагаанд дасан зохицох чадвар муутай гэсэн үр дүн гарсан байна. Судалгаанд нийт оролцогчдын 65.9% нь сургалтын үйл ажиллагаанд дасан зохицох чадвар дунд зэрэг байгаагаас харахад оюутнуудын дасан зохицох чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах хэрэгцээ шаардлага байна.

Судалгаанд оролцсон нийт оюутнуудын 22.8% хувь буюу 43 оюутан сургуулийн орчинд дасан зохицох чадвар сайтай, 70.9% буюу 134 оюутан сургуулийн орчинд дасан зохицох чадвар дунд зэрэг, 6.3% буюу 12 оюутан сургуулийн орчинд дасан зохицох чадвар муутай гэсэн үр дүн гарсан байна. Судалгаанд оролцсон нийт оюутнуудын 6.3% нь сургуулийн орчинд дасан зохицох чадвар муу байгаа нь тус тус тодорхойлогдлоо (Зураг 1).



Зураг 1. Нийгэм, хамт олон сургуулийн орчинд дасан зохицох чадварыг дамжаагаар нь харьцуулсан дүн

Судалгаанд оролцсон 1 дүгээр дамжааны оюутнуудын 12.5%, 2 дугаар дамжааны оюутнуудын 6,3% нь нийгэм, хамт олон сургуулийн орчинд дасан зохицох чадвар муу, 1 дүгээр дамжааны оюутнуудын 71.5%, 2 дугаар дамжааны оюутнуудын 70.9% нь нийгэм, хамт олон, сургуулийн орчинд дасан зохицох чадвар дунд зэрэг, 1 дүгээр дамжааны оюутнуудын 16%, 2 дугаар дамжааны оюутнуудын 22.8% нь нийгэм, хамт олон сургуулийн орчинд дасан зохицох чадвар сайтай гэсэн үр дүн гарсан байна. Үр дүнгээс

харахад 2 дугаар дамжааны оюутнуудын нийгэм хамт олон сургуулийн орчинд дасах чадвар 1-р дамжааны оюутнуудаас илүү буюу дасан зохицох чадвар сайн байна.

Судалгаанд оролцсон 1 дүгээр дамжааны оюутнуудын 13.5%, 2 дугаар дамжааны оюутнуудын 1.1% нь сургалтын үйл ажиллагаанд дасан зохицох чадвар муу, 1 дүгээр дамжааны оюутнуудын 53%, 2 дугаар дамжааны оюутнуудын 65% нь сургалтын үйл ажиллагаанд дасан зохицох чадвар дунд зэрэг, 1 дүгээр дамжааны оюутнуудын 34%, 2 дугаар дамжааны оюутнуудын 33.9% нь сургалтын үйл ажиллагаанд зохицох чадвар сайтай гэсэн үр дүн гарсан байна. Үр дүнгээс харахад 2 дугаар дамжааны оюутнуудын сургалтын үйл ажиллагаанд дасах чадвар 1 дүгээр дамжааны оюутнуудаас илүү буюу дасан зохицох чадвар сайн байна.

Судалгаанд хамрагдсан оюутнуудыг 21 аймгаар нь ангилж үзэхэд Увс, Завхан, Хөвсгөл, Баян-Өлгий аймгуудын оюутнууд судалгаанд хамгийн олон, хамгийн бага Дорноговь, Төв, Сүхбаатар, Өмнөговь, Говь-Алтай, Дархан -Уул аймгууд, Говьсүмбэр аймгийн оюутан судалгаанд оролцоогүй байна. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Сургалтын үйл ажиллагаанд дасан зохицох чадварыг тодорхойлсон дүн (Үндсэн захиргаагаар)

№	Үндсэн захиргаа	Дасан зохицох чадвар сайтай	Дасан зохицох чадвар дунд зэрэг	Дасан зохицох чадвар муутай
1	Улаанбаатар	19 (34.5%)	36 (65.5%)	0 (0%)
2	Орон нутаг	44 (32.8%)	88 (65.8)	2 (1.4%)

Улаанбаатар хотод оршин суудаг оюутнуудын 34.5% нь сургалтын үйл ажиллагаанд дасан зохицох чадвар сайн, 65.5% нь сургалтын үйл ажиллагаанд дасан зохицох чадвар дунд зэрэг, сургалтын үйл ажиллагаанд дасан зохицох муу оюутан байгаагүй, хөдөө орон нутгаас Улаанбаатар хотод ирж суралцаж буй оюутнуудын 32.8% нь сургалтын үйл ажиллагаанд дасан зохицох чадвар сайн, 65.8% нь сургалтын үйл ажиллагаанд дасан зохицох чадвар дунд зэрэг, 1.4% нь сургалтын үйл ажиллагаанд дасан зохицох чадвар муу байна. Нийгэм, хамт олны дунд дасан зохицох чадвар үндсэн захиргааны хувьд ($p=0.67$) ялгаатай, H_1 альтернатив таамаглал батлагдаж байна.

Оюутнууд мэргэжлээ сонгон суралцахдаа мэдлэг эзэмших сэдэлтэйгээр суралцсан байдлыг судалж үзэхэд мэдэг эзэмших сэдэл бага 9.52%, мэдлэг эзэмших сэдэл дунд зэрэг 26.46%, мэдлэг эзэмших сэдэл их байгаа нь 62.84% байна. Судалгаанд нийт хамрагдсан оюутнуудын дийлэнх хувь нь мэдлэг эзэмших сэдэлтэй байна.

Оюутны мэргэжил эзэмших сэдлийг судалж үзэхэд мэргэжил эзэмших сэдэл бага 14.81%, мэргэжил эзэмших сэдэл дунд зэрэг 19.05%, мэргэжил эзэмших сэдэл их 66.14%-ийг эзэлж байна. Оюутан мэргэжлээ өөрийн хүсэл сонирхлоор сонгон суралцаж байгаа тохиолдолд мэргэжил эзэмших сэдэл өндөр байх бөгөөд нийт оюутнуудын 85.19% нь мэргэжил эзэмших сэдлийн түвшин өндөр байгаа нь ирээдүйн сайн мэргэжилтэн болох эхлэл юм.

Оюутнуудын диплом авах сэдэл 19,58% нь бага, 57.14% нь диплом авах сэдэл дунд зэрэг, 23.28% нь диплом авах сэдэл их байна. Үүнээс харахад нийт судалгаанд хамрагдсан оюутнуудын дунд диплом авах сэдэлтэй оюутнууд харьцангуй бага байгаа сайн үр дүн ажиглагдаж байна.

Судалгаанд нийт оролцогчдын 3.17% нь мэргэжил сонголтын нийгмийн ач холбогдол бүхий дотоод сэдлийн түвшин бага, 12.7 % нь мэргэжил сонголтын нийгмийн ач холбогдол бүхий дотоод сэдлийн түвшин дунд зэрэг, 53.97% нь мэргэжил сонголтын нийгмийн ач холбогдол бүхий дотоод сэдлийн түвшин сайн, 30.16% нь мэргэжил сонголтын нийгмийн ач холбогдол бүхий дотоод сэдлийн түвшин маш сайн гэсэн үр дүн гарсан байна. Үр дүнгээс харахад мэргэжил сонголтын нийгмийн ач холбогдол бүхий дотоод сэдлийн түвшин өндөр байна. Оюутан мэргэжлээ сонгохдоо нийгмийн ач холбогдол бүхий дотоод сэдлийн түвшин өндөр байна гэдэг нь цаашдын сайн мэргэжилтэн болоход эергээр нөлөөлөх магадлалтай.

Судалгаанд нийт оролцогчдын 4.76% нь мэргэжил сонголтын хувийн ач холбогдол бүхий дотоод сэдлийн түвшин бага, 23.28% нь мэргэжил сонголтын хувийн ач холбогдол бүхий дотоод сэдлийн түвшин дунд зэрэг, 55.56% нь мэргэжил сонголтын хувийн ач холбогдол бүхий дотоод сэдлийн түвшин сайн, 16.40% нь мэргэжил сонголтын хувийн ач холбогдол бүхий дотоод сэдлийн түвшин маш сайн гэсэн үр дүн гарсан байна. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Дасан зохицох чадвар болон мэргэжил сонголтын сэдлийн хамаарлыг судласан дүн

Мэргэжил сонголтын сэдлийн төрөл	Хамт олон, сургуулийн орчинд дасан зохицох чадвар	Сургалтын үйл ажиллагаанд дасан зохицох чадвар	Хувийн ач холбогдол бүхий дотоод сэдэл	Нийгмийн ач холбогдол бүхий дотоод сэдэл	Гадаад сөрөг сэдэл	Гадаад эерэг сэдэл
Хамт олон, сургуулийн орчинд дасан зохицох чадвар	1.000					
Сургалтын үйл ажиллагаанд дасан зохицох чадвар	0.3163* 0.0000	1.0000				
Хувийн ач холбогдол бүхий дотоод сэдэл	0.3138* 0.0000	0.2265* 0.0017	1.0000			
Нийгмийн ач холбогдол бүхий дотоод сэдэл	0.2422* 0.0008	0.1650* 0.0233	0.7963* 0.0000	1.0000		
Гадаад сөрөг сэдэл	0.1322 0.0698		0.6851* 0.0000	0.6543* 0.0000	1.0000	
Гадаад эерэг сэдэл	0.2269* 0.0017		0.7785* 0.0000	0.6604 0.0000	0.7945* 0.0000	1.0000

Судалгааны үр дүнгээс харахад хамт олон сургуулийн орчинд дасан зохицох чадвар нь сургалтын үйл ажиллагаанд дасан зохицох чадвар хоорондоо хамааралтай, мэргэжил сонголтын хувийн ач холбогдол бүхий дотоод сэдэл нь нийгэм, хамт олон сургуулийн орчинд дасан зохицох чадвар, сургалтын үйл ажиллагаанд дасан зохицох чадвартай өндөр хамааралтай, мэргэжил сонголтын нийгмийн ач холбогдол бүхий сэдэл нь нийгэм, хамт олон сургуулийн орчинд дасан зохицох чадвар, сургалтын үйл ажиллагаанд дасан зохицох чадвар, хувийн дотоод ач холбогдол бүхий дотоод сэдэлтэй өндөр хамааралтай, гадаад эерэг сэдэл нь хувийн ач холбогдол бүхий дотоод сэдэл, нийгмийн ач холбогдол бүхий дотоод сэдэл шууд хамааралтай байгаа нь статистик ач холбогдолтой байна. (Хүснэгт 3)

Хүснэгт 3. Дасан зохицох чадвар болон сурах сэдэл хоорондын хамаарал судалсан дүн

Сурах сэдлийн төрөл	Хамт олон, сургуулийн орчинд дасан зохицох чадвар	Сургалтын үйл ажиллагаанд дасан зохицох чадвар	Диплом авах сэдэл	Мэдлэг эзэмших сэдэл	Мэргэжил эзэмших сэдэл
Диплом авах сэдэл			1.00		
Мэдлэг эзэмших сэдэл	0.12 0.07	0.2649* 0.0002	0.1651* 0.0232	1.00	
Мэргэжил эзэмших сэдэл	0.13 0.06		0.2750* 0.0001	0.3596* 0.0000	1.00

Сургалтын үйл ажиллагаанд дасан зохицох чадвар нь мэдлэг эзэмших сэдэлтэй r=0.26 сул эерэг, диплом авах сэдэл мэдлэг эзэмших сэдэлтэй r=0.16 сул эерэг, мэргэжил эзэмших сэдэл r=0.27 сул эерэг хамааралтай, Мэдлэг эзэмших сэдэл мэргэжил эзэмших сэдэлтэй r=0.35 сул эерэг хамааралтай байна. (Хүснэгт 4)

Хүснэгт 4. Сургуулийн орчинд дасан зохицох, сургалтын үйл ажиллагаанд дасан зохицох чадварын нэг хүчин зүйлийн регрессийн шинжилгээ

Хувьсагч	Coff.	Std.Err	P>t	95% Conf.interval	
Сургуулийн орчин, нийгэм хамт олонд дасан зохицох чадвар	.315	0.6	0.000	0.17	0.45
Сургалтын үйл ажиллагаанд дасан зохицох чадвар	.316	.06.	0.000	0.17	0.45

Сургалтын үйл ажиллагаанд дасан зохицох оноо нэгээр нэмэгдэхэд сургалтын орчинд дасан зохицох чадвар 0.31 дахин нэмэгдэж байгаа нь статистик ач холбогдол бүхий байна. Үүнээс үзэхэд сургуулийн орчинд дасан зохицох чадвар, сургалтын үйл ажиллагаанд дасан зохицох чадвар хоёр хоорондоо хамааралтай бөгөөд сургуулийн орчиндоо дасан зохицож чадсан оюутан сургалтын үйл ажиллагаанд дасан зохицож амжилттай суралцах боломж бүрдэж байна.

Судалгааны үр дүнгээс харахад мэдлэг эзэмших сэдэл нь сургалтын үйл ажиллагаанд дасан зохицох чадвартай шууд хамааралтай, мэргэжил эзэмших сэдэл нь диплом авах сэдэл, мэдлэг эзэмших сэдэлтэй шууд хамааралтай байна гэсэн статистик магадлал бүхий үр дүн гарсан байна.

Хэлцэмж: СудлаачД.Дарьмаа(2021)нарынОтгонтэнгэр их сургуулийн 1 дүгээр дамжааны оюутны дасан зохицлын судалгаанд оюутны сургалтын орчинд дасан зохицох чадвар муу 15.4%, дундаж 43.3%, сайн 41.3%, хэвийн биш тархалттай байгаа нь бидний судалгааны үр дүнтэй ойролцоо байна.[11] Судлаач Г.Нямсүрэнгийн (2018) ХААИС-ийн 1 дүгээр дамжааны 80 оюутнууд хамруулан судалгааны үр дүнгээс харахад 71,4% дасан зохицох чадвар сайн, 23,4% нь дасан зохицох чадвар муу гэсэн үр дүн гарсан байгаа нь бидний судалгааны үр дүнтэй харьцуулахад дасан зохицох чадвар муу оюутнуудын эзлэх хувь илүү олон байна.[12]

Камис, Яаков нарын (2002) Малайз улсын их дээд сургуулиудын оюутнуудын дасан зохицлыг судлан үзэхэд дасан зохицлын хувьд асуудал үүсэх, дасан зохицож чадахгүй байгаагаас оюутнууд сургуулиа төгсөж чадахгүйд хүрч байна[1] гэсэн үр дүн нь бидний судалгааны үр дүнтэй тохирч байна.[2] АНУ-ын судлаач В.Тинто (1996) АНУ-ын оюутнуудад хийсэн судалгаагаар оюутнуудын 40% дасан зохицох чадвар муу байгаагаас үүдэн сургууль завсардсан, мөн тэдгээр оюутнуудын 57% нь 2 дахь жилийнхээ эхэнд сургуулиасаа гарсан гэсэн судалгаа үр дүн байна[7].

Дүгнэлт:

1. Судалгаанд хамрагдсан нийт оюутнуудын нийгэм, хамт олон сургуулийн орчинд дасан зохицох чадвартай оюутан судалгаанд оролцсон нийт оюутнуудын дийлэнх хувийг эзэлж байна. Оюутнууд нийгэм, сургуулийн орчин, анги хамт олондоо дасан зохицох чадвар сайн байх нь хичээлдээ явах идэвх санаачлага нэмэгдэж өөрийн сонгосон мэргэжлээ сайн эзэмшихэд нөлөөлж байна.
2. Судалгаанд нийт хамрагдсан оюутнуудын 98.9% нь сургалтын үйл ажиллагаанд дасан зохицох чадвар сайн, дунд зэрэг гэсэн үр дүн гарсан байгаагаас харахад нийгэм, хамт олон, сургуулийн орчинд дасан зохицож чадсан оюутнууд, сургалтын үйл ажиллагаандаа дасан зохицоход хялбар болж байна. Нийгэм хамт олон сургуулийн орчинд дасан зохицох чадвар, сургалтын орчинд дасан зохицох чадвар хоорондоо хамааралтай байна.
3. Оюутны дасан зохицох чадвар нь сурлагын амжилтад эергээр нөлөөлж, хамааралтай байна гэсэн статистик үнэн бодит үр дүн гараагүй харин мэргэжил сонголтын хувийн ач холбогдол бүхий дотоод сэдэл нь сурлагын амжилт, дасан зохицох чадвар хоёрт нөлөөлж байгаа нь харагдаж байна.

Ном зүй:

1. *Tinto V. Leaving College: Rethinking the Causes and Cures of Student Attrition. Second Edition. University of Chicago Press. 1993;1(1).*
2. *Khamis A, Fauziah Yaakub N, Shaari A. Adjustment to college life and academic performance among Universiti Utara Malaysia students. google scholar . Published 2002. https://scholar.google.com/scholar?hl=en&as_sdt=0%2C5&q=Adjustment+to+college+life+and+academic+performance+among+Universiti+Utara+Malaysia+students&btnG=*
3. *Abdolreza Gilavand. The Comparison of Iranian and Foreign Students' Motivations to Choose Dentistry Field of Study. DOAJ (DOAJ: Directory of Open Access Journals). 2016;4(1).*
4. *Gallagher JE, Clarke W, Eaton KA, Wilson NH. Dentistry – a professional contained career in healthcare. A qualitative study of Vocational Dental Practitioners' professional expectations. BMC Oral Health. 2007;7(1). doi:https://doi.org/10.1186/1472-6831-7-16*
5. *Gilavand A, Barekat G, Hosseinpour M. Evaluation of Dental Students' Motives and Viewpoints on Their Career Choice in Ahvaz. Jentashapir Journal of Health Research. 2015;6(6). doi:https://doi.org/10.17795/jjhr-30384*
6. *Ajzen I, Kruglanski AW. Reasoned action in the service of goal pursuit. Psychological Review. 2019;126(5). doi:https://doi.org/10.1037/rev0000155*
7. *Tinto V. Reconstructing the First Year of College. Planning for Higher Education. 1996;25(1):1-6. Accessed May 3, 2023. https://eric.ed.gov/?id=EJ558395*
8. *Clinciu AI. Adaptation and Stress for the First Year University Students. Procedia - Social and Behavioral Sciences. 2013;78(1):718-722. doi:https://doi.org/10.1016/j.sbspro.2013.04.382*
9. *Дубовицкая Т.Д., Крылова А.В. Методика исследования адаптированности студентов в вузе. Психолого-педагогические исследования. 2010;2(2). Accessed May 3, 2023. https://psyjournals.ru/journals/psyedu/archive/2010_n2/27814*
10. *Р. В Овчарова. Мотивы выбора профессии (Овчарова). psy-tests.org. Published 1996. Accessed May 3, 2023. https://psytests.org/work/mvproo.html*
11. *Д.Дарьмаа, Б.Анахнаран. Отгонтэнгэр их сургуулийн нэгдүгээр курсийн оюутнуудын дасан зохицлын судалгаа. otgontenger.edu.mn. Published 2021. http://library.otgontenger.edu.mn/books?id=961*
12. *Г.Нямсүрэн. Дасан зохицох чадварыг үнэлэх. 2018*

Examining the relationship between adaptability and student academic achievement and career choice motivation

Batchuluun P[1], Pagmadulam S[1,2], Enkhbayar B[3], Tuul M[4]

[1]School of Health, Etugen university
[2]School of Education, MNUMS
[3]School of Humanities, Otgontenger university
[4]"Avicenna" science center
E-mail: abatchuluun.p@etugen.edu.mn, Tel: +976-89041919

Background: Studies have shown that studying at university is one of the most stressful periods in an individual's life and one of the most vulnerable to psychological stress. Students at this time receive less support and more responsibilities and workloads. Compared to working people, university students are exposed to more stress that is not suitable for them. There are no statistically valid results that show that the adaptability of students has a positive effect on academic success. On the other hand, it can be seen that the personal importance of the internal motivation of career choice affects both academic success and adaptability.
Aim: To study the impact of students' adaptability on academic success
Materials and Methods: The study was conducted between March 30 and April 5, 2023, using a one-moment survey design, and consent was obtained from 189 students through an informed consent form.
Results: 189 second-year medical students of Etugen University participated in the study, 30 (15.9%) were male and 159 (84.9%) were female. 71% of the respondents or 134 students are from rural areas and 29% or 55 students live in Ulaanbaatar. It was found that 33.9% of all students participating in the study or 63 students have a good ability to adapt to learning activities, 65.9% or 124 students have a moderate ability to adapt to learning activities, and 1.1% or 2 students have a poor ability to adapt to learning activities.
Conclusion: Among all the students involved in the study, students who are able to adapt to the social and community school environment are the majority of the students who participated in the study. A good ability of students to adapt to society, school environment, and classmates increases their initiative to go to class, which affects their ability to master their chosen profession. 98.9% of the students who took part in the research had a good or moderate ability to adapt to learning activities. It can be seen that students who have adapted to the society, community, and school environment find it easier to adapt to their learning activities. The ability of society to adapt to the school environment and the ability to adapt to the learning environment are interrelated.

Keywords: Learning environment, Adaptation, Success